**Засгийн газраас баталсан “Хүнсний баталгаат байдал” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн**

2009 оны жилийн эцсийн байдлаар

| № | Хөтөлбөрийн агуулга | | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо | | 2009-2-04 № 32. |
| 2 | Хөтөлбөрийн зорилго | | Иргэн, төр, олон нийт, хувийн хэвшлийн зохистой оролцоог хангах замаар нийт хүн амыг тэжээллэг, аюулгүй хүнсээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангаж, эрүүл аж төрөх болон хөдөлмөрийн бүтээмжийг нь дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх |
| 3 | Хөтөлбөрийн зорилтууд /Үе шатны хугацаатай нь авч үзэх/ | 2009-2012<br>2013-2016 | 1.Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг ойрын болон хэтийн хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсронгуй болгох<br>2.Эдийн засаг, санхүү, бизнесмйн таатай орчин бүрдүүлж дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх<br>3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, салбар дундын зохицуулалт болон боловсон хүчний чадавхийг сайжруулах<br>4.Гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулах<br>5.Хот, хөдөөгийн болон улирлаас хамаарах хүнсний хүртээмжийн ялгааг багасгах<br>6.Байгалийн гамшиг, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний хомсдолын үед хүн ам, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах<br>7.Хүнсний үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж Монгол брэндийн хүнс экспортлох нөхцлийг бүрдүүлэх<br>8.Хүнсний түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулахбүх дамжлагад хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлуудыг нэвтрүүлж бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах<br>9.Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналт, мэдээллийн сүлжээ, үйл ажиллагааг сайжруулах<br>10.Ундны усны хүртээмж, чанар, аюулгүй байдлыг сайжруулах<br>11.Монгол хүний зохистой хооллолтын зөвлөмжийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, хоол тэжээлийн талаархи хүн амын боловсролыг дээшлүүлэх<br>12.Хоол тэжээлтэй холбоотой өвчин эмгэгээс сэргийлэх, хяналт тавих<br>13.Зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Зардал /сая төг/ | Төсөв /шаардагдах нийт зардал/ | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын төсөв хийгдээгүй. Хөтөлбөр 2009.2.04-нд батлагдсан болохоор 2009 онд хөрөнгө төсөвлөгдөөгүй,өмнөх “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” хөтөлбөрийн санхүүжилтэд 13.0 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулахаар ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 04 дүгээр сарын 06-ны 81 дүгээр тушаалаар баталжээ. |
| | | Гүйцэтгэл /өссөн дүнгээр/ | Улсын төсвөөс 13.0 сая төгрөг |
| | | Үүнээс тухайн жилд зарцуулсан | 13.0 сая төгрөг |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Хөтөлбө-рийн хэрэг-жилтийн үнэлгээ | Биелэлтийн хувь | Дүн | 100 | 90 | 70 | 50 | 30 | 10 | 0 |
| | | Зорилтын тоо | 13 | - | 1 | 1 | 2 | 4 | 4 | 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл | | Төлөвлөсөн | Гүйцэтгэл | % |
| | Шалгуур үзүүлэлт тус бүрээр/ харьцуулах суурь он 2007/ | Эрх зүй, эдийн засгийн орчин, үйлчилгээ | **2009-2012 он:** орчин бүрдсэн. Үйлчилгээ 2.5 дахин нэмэгдсэн. | “Хүнсний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, “ХАА-нбараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн төслүүдийг боловсруулсан, Засгийн газрын ЖДҮ-ийн тоног төхөөрөмжийг гаалийн болон бусад татвараас чөлөөлсөн 2009 оны 316 дугаар тогтоол | 30.0 |
| | | Хүнсний аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ | **2009-2012 он:** 30 хувиар нэмэгдсэн | 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2008 онтой харьцуулахад 22.1% -иар өсчээ. | 294.7 |
| | | Хүнсний аюулгүй байдлын хяналт | **2009-2012 он:** Шинэ тогтолцоонд шилжинэ | Хүнсний үйлдвэрлэлд HACCP, GMP, GHP тогтолцоо нэвтрүүлэх анхны алхам хийгдэж байна. | 10.0 |
| | | Сүүний үүлдрийн үхрийн тоо, үйлдвэрт хүлээн авсан сүүний хэмжээ | **2009-2012 он:** үхрийн тоо 8.0 мянгаас доошгүй. Сүү 20.0 мянгаас доошгүй тонн | Сүүний үхрийн аж ахуйн тоо 523, тэдгээрт байгаа үхрийн тоо 19.3 мян.тол. Үйлдвэрт хүлээн авсан сүү 12.4 мян.т | 100.0 |
| | | Мах үйлдвэрлэл | **2009-2012 он:** Үйлдвэрлэл 35 %-иар нэмэгдэнэ. Үйлд-вэрт 50 мян.т бэлтгэнэ. 20.0 мян.т мах экспорт-лоно. 10.0 мян.т махыг эрчимжсэн аж ахуйгаас бэлтгэнэ. | Үйлдвэрт бэлтгэсэн мах 18.3 мян.т. Экспортолсон мах 17.9 мян.т | 66.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин | **2009-2012 он:** Мах, сүү, гурил, төмс, хүнсний ногоо 100%, өндөг 65-70%, цөцгийн тос, загас 15%, ургамлын тос 5-10% | Мах 100%, сүү 94 %, гурил 69%, төмс 118.2%, хүнсний ногоо 48.5%, ургамлын тос 0.0%, | 100.0 |
| | | Хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлт | **2009-2012 он:** Гурил, цагаан будаа, элсэн чихэр 10-14 хоног, хүнсний буудай нийт хэрэгцээний 30-35 % | Нөөцөлсөн хүнсний буудай 152.0 мян.т. Хэрэгцээний 36.2% | 103.4 |
| | | Буудайн усалгаатай тариалан | **2009-2012 он:** Талбай 53.0 мян.га, нийт ургацын 25%-иас доошгүйг авна. | Талбай 10 мян. га орчим. Ургац 18.7 мян.т. /4.8%/ | 75.0 |
| | | Тармлын нэр төрөл, сэлгээний ээлжийн тоо, цулгуй уриншийн хэмжээ | **2009-2012 он:** Нэр төрөл сэлгээний ээлжийн тоо нэмэгдэнэ. Цулгуй уриншийн хэмжээ 20% буурна. | Тармлын нэр төрөл, сэлгээний тоонд өсөлт гараагүй. Цулгуй уриншийн хэмжээ 2009 онд 4.9% өссөн | 0.0 |
| | | Хот суурингийн хэрэгцээнд нийлүүлэх мах, сүүний аж үйлдвэрийн боловсруулалтын түвшин | **2009-2012 он:** Мах 30%, сүү 20% | Махны 6.9%, сүүний 9.7% | 56.5 |
| | | Бөөний худалдааны сүлжээний хамрах хүрээ | **2009-2012 он:** Нийт сумдын 25%-иас доошгүй хамрагдана. | 18 аймгийн 116 сум хамрагдалт 34.5% | 138.0 |
| | | Мах, сүүний гарал, эрүүл ахуй, ариун цэврийн хяналт | **2009-2012 он:** Хяналт сайжирна. | 2008 оныхоос зарчмын өөрчлөлт гараагүй | 0.0 |
| | | Хүнсний импортын хяналт | **2009-2012 он:** Урьдчилсан хяналтын тогтолцоо бүрдэ-нэ. | 2009 онд тогтолцоог бүрдүүлэх чиглэлд арга хэмжээ авагдаагүй. | 0.0 |
| | | Хүнсний хяналтын нэгдсэн тогтол-цоо | **2009-2012 он:**Түүхий эдээс бэлэн бүтээгдэхүүн хүр-тэлх хяналтын нэгдсэн тогтолцоо бий болно. | Нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх судалгаа хийж байгаа. Шадар сайдын ажлын алба дээр төсөл хэрэгжүүлж байна. | 30.0 |
| | | ХАА, үйлдвэр, эрүүл ахуйн зохистой дадлуудын эзэмшилт | **2009-2012 он:** Фермер, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 20%-иас доошгүй нь эзэмшинэ. | GMP, GHP-ийн сургалтад 105 хүнийг хамруулсан. | 10.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх металлын үлдэгдэл, хорт бодисын хяналт, тандалт | **2009-2012 он:** Чадавхи сайжирна. | УМЭАЦТ лаборато-рийн тоног төхөөрөмж шинэчилсэн. | 50.0 |
| | | Хүн амын хоол тэжээлийн сургалт | **2009-2012 он:** Хөтөлбөр, стандартууд бий болно. 200-аас доошгүй сургагч багш бэлтгэнэ. | ЭМС-ын хүрээнд ОНМХ-ээр сурталчилгаа явагдаж байна. Зарим веб сайтууд ажилладаг. | 50.0 |
| | | Бага насны хүүх-дийн эмчилгээ-сувиллын хоолны газар, сургалтын танхим | **2009-2012 он:** Бүх аймгийн төв, нийслэлийн дүүрэгт тус бүр 1-ээс доошгүй байгуулна. | Сувиллын хоолны газар,сургалтын танхим байгуулах ажил үргэлжлэн хийгдэж байна.Гэхдээ бага насны хүүхдийн гэж ангилагдаагүй. | 50.0 |
| | | Зохицуулах үйл-чилгээтэй болон баяжуулсан хүнс-ний үйлдвэрлэл | **2009-2012 он:** 50%-иар нэмэгдэнэ | Иоджуулсан давс, баяжуулсан гурилын үйлдвэрлэл суурь оны түвшингээс буурсан | 0.0 |
| | | Хүн амын хоол тэжээлтэй хол-боотой өвчлөлийн байдал | **2009-2012 он:** 5 хүртэлх насны хүүхдийн Д аминдэ-мийн дутал 1.2 дахин, ууraг, илчлэг, А аминдэ-мийн дутал, цус бага-далт, жирэмсэн эмэгтэй-чүүдийн цус багадалт тус бүртээ 1.5 дахин, 7-12 насны хүүхдийн бахлуур 3 дахин буурна. | Эдгээр үзүүлэлтүүд нь үндэсний хэмжээний хоол тэжээлийн байдлын судалгаагаар гардаг тул 2009 онд харгалзах гүйцэтгэлийг гаргах боломжгүй байна. | - |
| | | Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэ-жээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөл-бөрийн хэрэгжилт | **2009-2012 он:** Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт хэрэгж-сэн байна. | Хөтөлбөр батлан хэрэгжүүлж эхэлсэн. 25.3 мянган иргэнд сар бүр 14 мян.төг-ийн хүнс худалдан авах талоныг олгожээ. | 70.0 |

| | | |
|---|---|---|
| 7 | Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц | Хөтөлбөрийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХХААХҮ-ийн сайдын 2009.06.04-ний 125 дугаар тушаалаар баталсан. Зөвлөл 2009.08.17 анхдугаар хурлаа хийсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулж ХХААХҮ-ийн сайдын 2010.01.22-ний 13 дугаар тушаалаар батлуулсан. “Хандивлагчдын дээд хэмжээний зөвлөлдөх уулзалт”-ыг 2009.10.08-нд хийж хөтөлбөрийг танилцуулжээ. “Хүнсний баталгаат байдал” дэд хөтөлбөрийг 1 аймаг, нийслэл баталсан ба 2 аймаг төслийг нь боловсруулсан байна. Хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан ойлгуулах зорилгоор хөтөлбөрийг товхимол болгон 1000 хувь хэвлүүлж түгээх, МҮОНР-гоор Пүрэв гариг бүр 10 минутын нэвтрүүлэг, TV5, FM радионуудаар нэвтрүүлэг хийж эхлэсэн. |
| 8 | Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/ | Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь удирдлага зохион байгуулалтын бүтцийг бий болгох, төлөвлөгөө батлах, хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан ойлгуулах зэрэг эхлэлийн шатандаа байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрчимтэй бус, удаан байна. Хөтөлбөр хэрэгжүүлэлт бараг эхлээгүй байгаа болохоор үр дүн, үр ашиг, үр өгөөжийн талаар дүгнэлт өгөх боломжгүй байна. |
| 9 | Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын ажлын уялдааг зохицуулах үүрэгтэй хөтөлбөрийн Үндэсний хорооны үйл ажиллагаа тогтмол биш байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эхлэл удаан байна. 2009 онд санхүүжилт хангалтгүй байсан. |
| 10 | Эдгээрээс гарах арга зам | Хөтөлбөрийн Үндэсний хорооны хурлыг улирэлд 1-ээс доошгүй хийж удирдлагаар хангах, тайлагнах тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах шаардлагатай. |
| 11 | Хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ | Хөтөлбөр хэрэгжүүлэх эхний үеийн байдлаар оролцогч талуудын хамтын ажиллагаа хангалтгүй байна. |
| 12 | Хөтөлбөрийн талаарх санал / өөрчлөн сайжруулах болон бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар гэх мэт/ | Хөтөлбөрийн санхүүжилтийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан урьдчилан үндэслэлтэй тооцон гаргах. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, үр дүнгийн он онд хүрэх түвшинг улс орны санхүүгийн боломжид тулгуурлан бодитой тогтоох. Хөтөлбөрийг төслөөр дамжуулан хэрэгжүүлэх зарчмыг баримтлан тодорхой төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх. |
| 13 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаархи санал/дэд хөтөлбөртэй байх, тухайн аймаг заавал хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох гэх мэт/ | Орон нутаг хөтөлбөрийн хүрээнд дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгаа. 2009 онд энэ ажил туйлын хангалтгүй байна. Нийслэл болон 2 аймаг дэд хөтөлбөр боловсруулж батлуулсан. Бусад аймгууд одоогоор дэд хөтөлбөргүй байна. |

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Т.ГАНТУЛГА